



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сити тоувер хотел ХХК-ийн “Хөвсгөл лэйк” зочид буудлын 16/039, Номадс Резидэнс ХХК-ийн “Хотел найн” зочид буудлын 16/083, Ундруул сифан ХХК-ийн “Ундруул” зочид буудлын 17/011, Монхурд ХХК-ийн “555” зочид буудлын 13/22 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.


ДАРГА



Д.БАТСҮХ

1150500055

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 03 сарын 07
өдрийн 18 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2018.03.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сити тоувер хотел ХХК	5997224	Хөвсгөл лэйк	СБД-ийн 8-р хороо Бага тойруу 14200
2	Номадс Резидэнс ХХК	5839505	Хотел найн	СБД-ийн 8-р хороо Амарын гудамж 2
3	Ундруул сифан ХХК	2094207	Ундруул	БЗД-ийн 4-р хороо 13345 Их тойруу 24/3
4	Монхурд ХХК	2068974	555	СХД-ийн 18-р хороо ЭТӨЧ 139 тоот
5	Ти жи и ХХК	5471028	Либерти	БГД-ийн 9-р хороо Ард Аюуш 35/3
6	Юу шанг тоу зи ХХК	6243711	Хэ нан	БГД-ийн 5-р хороо Гурван Эрдэнэ БДС барилга
7	Саранжим ХХК	5226589	9н9	БГД-ийн 11-р хороо 4-р хороолол 16061

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 03 сарын 07
өдрийн 14/17 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.03.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Дээж булаг ХХК	2554429	Шонхор	СХД-ийн 13-р хороо Өнөр 198-10
2	Буян даш ХХК	5913519	Од	СХД-ийн 6-р хороо тоосгоны 3-34а
3	Хэрлэн буян ХХК	2547163	Лойт хаус	БГД-ийн 11-р хороо өөрийн өмчлөлийн 3 давхар байшин.
4	Их алтай трейд ХХК	2565595	Хан	БГД-ийн 9-р хороо Их алтай трейд

--ooOoo--